



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 11 сарын 12 өдөр

Дугаар 0/436

Улаанбаатар хот

Налайх дүүргийн “Цэцэрлэгжүүлэлтийн алба”-ны
эргэлтийн бус хөрөнгийг данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2019 оны 11 дугаар сарын 08-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 9,831,500.0 /есөн сая найман зуун гучин нэгэн мянга таван зуун/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Налайх дүүргийн “Цэцэрлэгжүүлэлтийн алба” /О.Уранчимэг/-д зөвшөөрсүгэй.


2. Данснаас хасагдаж буй эргэлтийн бус хөрөнгөнөөс 6 нэр төрлийн 6,241,500.0 /зургаан сая хоёр зуун дөчин нэгэн мянга таван зуун/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор устгалын акт үйлдэн зохих журмын дагуу устгах, 6 нэр төрлийн 3,590,000.0 /гурван сая таван зуун ерэн мянган/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг Өмчийн ашиглалт, удирдлагын газарт актаар хүлээлгэн өгч, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Налайх дүүргийн “Цэцэрлэгжүүлэлтийн алба” /О.Уранчимэг/-д үүрэг болгосугай.

3. Татан төвлөрүүлж буй хөрөнгийг худалдан борлуулах ажлыг зохион байгуулахыг Урт цагаан үйлчилгээ, аж ахуйн төв /П.Батжаргал/-д үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга Д.Төмөрбаатарт даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ

Ш.ҮНЭНБАТ



115050001289

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын даргын 2019 оны 11...сарын 12 өдрийн 4/136 дугаар тушаалын хавсралт



Актлах эргэлтийн бус хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Налайх дүүргийн Цэцэрлэгжүүлэлтийн алба ОНӨААТҮГ

№	Эд хөрөнгийн нэр	Ашигласан жил	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	Эвдрэл гэмтэл	ЭБХХХ комиссын хурлын шийдвэр
Машин тоног төхөөрөмж										
1	Зургын аппарат /nicon/	5	ш	1	198,000	198,000	198,000	0	эвдэрсэн	татах
2	Зөөврийн компьютер /samsung/	5	ш	1	1,540,000	1,540,000	1,540,000	0	эвдэрсэн	татах
3	Кабелийн утас	5	ш	1	2,750,000	2,750,000	2,750,000	0	тасарсан	актлах
4	Цахилгаан үүсгүүр	5	ш	1	1,485,000	1,485,000	1,485,000	0	эвдэрсэн	татах
	Тоног төхөөрөмжийн дүн					5,973,000				
Тавилга эд хогшил										
5	Туг	5	ш	1	180,000	180,000	180,000	0	урагдсан	татах
6	Тугны суурь	5	ш	1	79,000	79,000	79,000	0	салсан	татах
7	Тумбочка 3 нүдтэй	10	ш	4	76,500	306,000	306,000	0	эвдэрсэн	актлах
8	Хар сандал	10	ш	4	27,000	108,000	108,000	0	эвдэрсэн	татах
	Тавилга, эд хогшлын дүн					673,000				
Биет бус хөрөнгө										
9	Архив бичиг хэргийн программ	5	ш	1	770,000	770,000	770,000	0	уншихгүй	актлах
10	Сүлжээ программ	5	ш	1	50,000	50,000	50,000	0	тасарсан	актлах
11	Санхүүгийн программ	5	ш	1	770,000	770,000	770,000	0	уншихгүй	актлах

	Биет бус хөрөнгийн дүн							1,590,000				
Бусад хөрөнгө												
12	Цэцгийн мандал	5	ш	4		398,875		1,595,500	1,595,500	0	ТОХИЖИЛТЫН ажлаар буулгагдсан	актлах
	Бусад хөрөнгийн дүн							1,595,500				
	Нийт данснаас хасах хөрөнгийн дүн											
	Үүнээс: Татан төвлөрүүлэх хөрөнгө											
	Актлах хөрөнгө											
								9,831,500				
								3,590,000				
								6,241,500				